

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даваа	Дугаар	L351
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Сайхан-Овоо сум
Төрсөн газар	Сайхан-Овоо сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хутагт ламын хийд	Сүм хийдийн дугаар	ДУСО 016
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-рсарын 13	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хутагт ламын хийд

Жужа: Та хэдэн настай лам болсон бэ?

Даваа: Манай аав лам хүн байсан. Намайг таван настай хөдөө хэдэн малтай байхад Жамьяншарав гэдэг зиндааныхаа нэг ламтай ирээд намайг лам болгоно гээд энэ хийдэд авчирч би таван жил шавилсан ухаантай. Тэгээд гучин долоон онд хар болоод явсан.

Жужа: Энд хичнээн лам сууж байсан бэ?

Даваа: Өө өчнөөн олон лам нар байсан. Эрдэнэдалайгаас Дэлгэрцогтоос одоо энэ хавийн сумдаас хүртэл олон лам нар сууж байсан, нарийн тоог нь мэдэх биш.

Жужа: Та аль дуганд сууж байсан бэ?

Даваа: Тэр зүүн талын дуганд суудаг байсан, зүүн ламиран гэж. Тэнд л банди нарыг голдуу суулгадаг. Зандраа гуай гэж гэсгүй нь байсан.

Жужа: Тэр дуган ямар шүтээнтэй байсан бэ?

Даваа: Өө мэдэхгүй. Их л олон бурхан шүтээн байсан. Бага байсан болоод сайн мэдэхгүй байна.

Энэхүү нэр дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Ламиран дацангийн жас гэж байсан уу?

Даваа: Тэр баруун өмнө нэг гэрийн буурь байгаа, тэр ламирангийн жас байсан.

Жужа: Хойд хийд буюу Дарь ламын хийдэд ямар ямар дуганууд байсан бэ?

Даваа: Өө мэдэхгүй их олон дуган байсан. Бүгдэд нь л хурал ном хурдаг байсан. Хамаагүй тэрүүгээр чинь явахгүй, томхон банди нараас айна. Тэд шоглоно./ инээв /

Жужа: Цам майдар эргэдэг байсан тухай ярьж өгнө үү?

Даваа: За хойд хийд дээр бол цам бол байхгүй. Харин банди нарын нэг хөөрхөн одоо дудар гэж нэг жижиг жүжиг гэмээр юм гардаг. Урд хийд дээр харин цам гардаг байсан. Цагаан өвгөн, Хашин хаан, хүүхдүүдтэйгээ гээд 108 цам гардаг байсан.

Жужа: Майдар эргэдэг байсан уу?

Даваа: Өө хоёуланд нь майдар эргэнэ. Ганжуур бас эргэнэ. Мөргөлчид бүр зуурчихна. Хийдээ тойроод л гороон замаараа эргэнэ. Хутагт ламын хийдийн хамба Лувсандорж гэж хүн байж байгаад л алга болсон.

Жужа: Энэ байшингуудын талаар ярина уу?

Даваа: Энэ цогчин дуган, тэр хойд талынх зуугийн дуган, тэр цаана чинь мамба, зүн урд талд жудийн дуган, тэнд гүнригийн дуган байсан. Бусдыг нь нэрийг нь холиод байна аа.

Жужа: Гавжийн дамжаа барьж байв уу?

Даваа: Барьж байсан, намар л голдуу барьдаг байсан.

Жужа: Аль овоог тахидаг байв?

Даваа: Тэр баруунтаа шашрын овоог тахина, урд хийд нь. Хойд хийд нь төрөөгийн арын овоог тахидаг байсан.

Жужа: Зоч лам нарын талаар ярьж өгөөч?

Даваа: Хойно байдаг зоч нарыг Чоймбол гэж гуй, урд хийдэд Гэмэл гэж гуй зоч нарыг тэрүүлдэг байсан.

Жужа: Эмэгтэй лам нар хандмаа нар байсан уу?

Даваа: Харин сүүлдээ олон эмэгтэй зоч болсон. Базар гуй энэ тэр гээд.

Жужа: Энэ хийд оронд хар бор хүн байсан уу?

Даваа: Энэ хийд оронд хар бор, эмэгтэй хүн хондоггүй байсан. Нэг тогооч өвгөн, тэгээд жасын мал гаргадаг хоёр гурван хар хүн л хоёр жас дээр байсан.

Жужа: Хятадууд байсан уу?

Даваа: Хятадууд байсан. Гороон дотроо хятадууд байхгүй. Тээр зүүн хойно гурав дөрвөн байшингийн түүр бий. Тэр хятад мхлагийн түүр.

Жужа: Хоёр хийд хэдэн онд хаагдсан бэ?

Даваа: 1937 онд.

Жужа: Тэгээд бүр хаагдсан уу?

Даваа: Тэгээд л лам нарыг нь бариад л сүм дуганыг нь лацдаад явсан. Миний эцгийг Амгалан гэж лам хүн байсан. Гучин долоон оны цагаан сарын дараа ерөөл хураад л дараа нь баригдаад явсан. Баригдсан лам нарыг

Энэхүү нэр дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өмнөговь руу л авч явсан гэдэг. Өмнөговьшиас шашны төлөөлөгч Батжав, Сахал Гэндэн гэдэг хоёр хүн ирж сүм дуганыг бурхан номыг бүгдийг шатаасан. Лам нар бурхан тахил судар номоо хамгаалж нууцлах ямар ч бололцоо олдоогүй. Тэгээд сүйтгээд хаячихсан.

Жужа: Дүйнхор дацанг хэзээ сэргээж эхэлсэн бэ?

Даваа: 2006 онд эхэлсэн.

Жужа: Бархан гэж ном хэвлэх газар байсан уу?

Даваа: Өө хоёр хийдэд хоёуланд нь байсан. Хойд хийдийнх суварганы доод талд байсан. Бурхан ном барална.

Жужа: Хийд хогныхоо асуудлыг яадаг байсан юм?

Даваа: Өө тэр баруун урд Гонгирынх гэж айл байсан юм. Тэдний хажуугийн жалганд хог хаядаг байсан, тэгээд л хөглөрч байдаг.

Жужа: 00-ын асуудал ямар байсан бэ?

Даваа: Өө тийм тусгайлсан юм байхгүй. Хурал ном гадаалахад манз цав барьсны дараа горооноос гадагш дуртай газраа энд тэндгүй л.../инээв/

Жужа: Жасын мал хэр зэрэг мал байсан бэ?

Даваа: Өө их мал байсан. Дандаа хөдөөгүүр. Намар болохоор хийд дээрээ авч ирээд бүх малаа тоолоод тамгалаад хөдөө гаргадаг.

Жужа: Тухайн үед сүсэгтэн олон ямар өргөл барьж өгч байв?

Даваа: Өө тогтсон дэг бол хадаг тэгээд л цагаан идээ, хонь мал томоохон аврал гүрэм хийлгэсэн хүн бол үхэр адуу өгнө. Тэгээд тэр жасын мал гэдэг чинь өргөл барьсны л юм шүү дээ.

Жужа: Ямар ямар овоо тахидаг байсан бэ?

Даваа: Манай энд урэгшаа яваад бурхан Шашраа тахичихдаг. Хойшоо яваад Баян-Өндөрөө тахичихдаг, цаашаа яваад Ламын хонхроо тахичихдаг. Энд Сайхан овоогоо тахичихдаг. Ийм л байсан.

Жужа: Том мяндаг тшаалтай лам нар жирийн лам нараас өөр хувцастай байсан уу?

Даваа: Өө гоц ялгаагүй. Манийн үед одоо шиг хүрэн жанч байгаагүй. дандаа шар жанчтай байсан. Харин том лам мяндагтнууд хуралд хурахаараа хар шаазтай байсан. Эд материалын хувьд бол ялгаа байхгүй. манай хийдийн хамгийн том лам нь Ёндон Минжүүр гуй байсан.

Жужа: Та Хошуу хийдэд очиж үзсэн үү, залуу байхдаа?

Даваа: Би хүүхэд байхдаа ижий датуулаад Хошуу хийдийн цамыг очиж үзсэн.

Жужа: Хошуу хийдийн цам, Хутагт ламын хоёр хоорондоо ялгаатай байсан уу?

Даваа: Өөр байсан, ялгаатай байсан.

Жужа: Хошуу хийдэд өндөр майдар байсан уу?

Даваа: Өө их өндөр майдар байсан. Нэг том бөмбөгөр оройтой дуганд байдаг.

Жужа: Тэр дуганд майдраас өөр бурхан байсан уу?

Даваа: Майдар ерөөсөө хоёр шавьтайгаа л байдаг байсан.

Энэхүү нэр дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 3

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Энд сор залдаг байсан уу?

Даваа: Өө зална, цамаа дуусахаар л сор зална.

Жужа: Чойжин бууж байсан уу?

Даваа: Өө үгүй байх, тэр байхгүй байсан байх.

Жужа: За баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 4